

БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

(1988 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон)

Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөлийн ивээл дор байгуулагдсан (үйлдсэн) энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд,

Олон улсын худалдааг хөнгөвчлөхийг хүсч,

Статистик мэдээлэл, нэн ялангуяа олон улсын худалдааны статистик мэдээлэл цуглуулах, харьцуулах болон дүн шинжилгээ хийх явдлыг хөнгөвчлөхийг хүсч,

Олон улсын худалдаанд барааны ангиллын нэг системээс нөгөөд шилжих явцад түүнийг дахин тодорхойлох, ангилах болон кодлохтой холбогдон гарч буй зардлыг багасгах, түүнчлэн худалдааны баримт бичгийг стандартчилах болон мэдээлэл дамжуулах ажиллагааг хөнгөвчлөхийг хүсч,

Технологийн хөгжил болон олон улсын худалдааны төлөв байдалд гарч буй өөрчлөлт нь 1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Брюссель хотноо үйлдсэн Барааг гаалийн тарифт ангилах Жагсаалтын тухай Конвенцийг өргөн цар хүрээтэй болгон шинэчлэхийг шаардаж буйг харгалзан,

Гаалийн болон статистик мэдээллийн зориулалтаар Засгийн газар болон худалдааны эрх ашгийн үүднээс шаардаж буй үзүүлэлт нь дээр дурдсан конвенцийн хавсралт жагсаалтаас хол давсныг харгалзан,

Олон улсын худалдааны хэлэлцээ хийхэд үнэн зөв, харьцуулах боломжтой мэдээлэл чухал болохыг харгалзан,

Уялдуулсан систем нь ачаа тээврийн тариф болон тээвэр үйлчилгээний статистик мэдээллийг тээврийн янз бүрийн төрлөөр гаргахад ашиглах зориулалттай гэж үзэж,

Уялдуулсан систем нь барааг тодорхойлох, кодлох худалдааны системд аль болох өргөн хүрээнд нэвтрүүлэх зориулалттай гэж үзэн,

Уялдуулсан систем нь худалдааны импорт, экспортын статистик мэдээ болон үйлдвэрлэлийн статистик мэдээг хооронд нь аль болох нягт уялдуулан холбох явдлыг хөхиүлэн дэмжих зориулалттайг харгалзан,

Уялдуулсан систем болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны стандарт ангилал (ОУХСА) нь хоорондоо нягт уялдаа холбоотой байх ёстой гэж үзэн,

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг олон улсын худалдаанд холбогдол бүхий янз бүрийн ашиг сонирхлын үүднээс ашиглахад тохиромжтой тариф/статистикийн нэгдсэн жагсаалт гаргах замаар хангах хүсэлтэй байгааг харгалзан,

Уялдуулсан систем нь технологийн хөгжил эсвэл олон улсын худалдааны төлөв байдалд гарч буй өөрчлөлтийн дагуу тухай бүр шинэчлэгдэж байх боломжоор хангахын чухлыг харгалзан,

Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөлөөс байгуулсан Уялдуулсан системийн хорооноос энэ чиглэлд хийж гүйцэтгэсэн ажлыг анхааралдаа авч,

Дээр дурдсан Жагсаалтын тухай конвенц нь эдгээр зорилтын заримыг хэрэгжүүлэхэд үр ашигтай байсан хэдий ч энэ чиглэлээр хүссэн үр дүндээ хүрэх хамгийн сайн арга зам нь олон улсын шинэ конвенц байгуулах явдал мөн гэдгийг харгалзан үзэж,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү конвенцийн зорилгоор:

(a) “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” (цаашид “Уялдуулсан систем” гэх) гэж энэхүү Конвенцид хавсаргасан зүйл болон мөр, мөн тэдгээрийн тоон код, хэсэг, бүлэг, мөрийн тайлбар бүхий жагсаалт болон Уялдуулсан системийн тайлбар дүрмийг;

(b) “Гаалийн тарифын жагсаалт” гэж импортын бараанд гаалийн татвар ногдуулах зорилгоор Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжоор тогтоосон жагсаалтыг;

(c) “Статистикийн Жагсаалт” гэж худалдааны импорт, экспортын статистик мэдээ гаргах зорилгоор мэдээлэл цуглуулах үүднээс Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас тогтоосон барааны жагсаалтыг;

(d) “Тариф/статистикийн нэгдсэн жагсаалт” гэж барааг импортлох үед мэдүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас хууль ёсоор шаарддаг гаалийн тарифын болон статистикийн нэгтгэсэн жагсаалтыг;

(e) “Зөвлөл байгуулах тухай конвенц” гэж 1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Брюссель хотноо үйлдсэн Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн тухай конвенцийг;

(f) “Зөвлөл” гэж өмнөх (e) заалтад дурдсан Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийг;

(g) “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргыг;

(h) “Соёрхон батлах” гэж соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсвэл батлахыг тус тус хэлнэ.

2 дугаар зүйл

Хавсралт

Энэхүү конвенцийн хавсралт тус конвенцийн салшгүй хэсэг болох бөгөөд уг конвенциос хийсэн ишлэл түүний хавсралтад нэг адил хамаарна.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хүлээх үүрэг

1. 4 дүгээр зүйлд тусгайлан заасныг баримтлан:

(а) Хэлэлцэн тохирогч Тал бүр энэ заалтын (с)-д зааснаас бусад тохиолдолд тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс өөрийн гаалийн тарифын болон статистикийн жагсаалтаа Уялдуулсан системд нийцүүлсэн байх үүрэг хүлээнэ. Ингэснээр тухайн улс өөрийн гаалийн тарифын болон статистикийн жагсаалтын хувьд дараах үүрэг хүлээнэ:

- (а) Уялдуулсан системийн бүх зүйл болон мөрийг тэдгээрийн тоон кодын хамт нэмэлт, өөрчлөлтгүйгээр хэрэглэх;
- (b) Уялдуулсан системийн тайлбар дүрэм, бүх хэсэг, бүлэг, мөрийн тайлбарыг хэрэглэх бөгөөд Уялдуулсан системийн хэсэг, бүлэг, зүйл, эсвэл мөрийн үйлчлэх хүрээг өөрчлөхгүй байх; мөн
- (c) Уялдуулсан системийн тогтоосон дарааллыг баримтлах.

(b) Хэлэлцэн тохирогч Тал бүр худалдааны импорт, экспортын статистик мэдээг Уялдуулсан системийн 6 оронгийн кодоор, эсвэл худалдааны нууцлалыг хамгаалах, эсвэл үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зэрэг онцгой шалтгаанаар хэвлэн нийтлэхийг хориглоогүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч тухайн Талын санаачилгаар түүнээс ч илүү нарийвчилсан түвшингээр гаргаж нийтийн хүртээл болгоно;

(c) Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тариф/статистикийн жагсаалтдаа өмнөх (а) (i), (а) (ii), (а) (iii)-д заасныг дагаж мөрдсөн бол Гаалийн тарифын жагсаалтдаа Уялдуулсан системийн мөрийг хэрэглэхийг энэ зүйлээр шаардахгүй.

2. Хэлэлцэн тохирогч Тал бүр энэ зүйлийн 1(а)-д заасны дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Уялдуулсан систем хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай зохицуулалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгаж болно.

3. Энэ зүйлийн заалт нь хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү конвенцийн хавсралтад дурдсан 6 оронгийн кодоос илүү нарийвчилсан задаргааг нэмж, кодолж байгаа бол өөрийн Гаалийн тарифын, эсвэл статистикийн жагсаалтад барааг Уялдуулсан системийн түвшингээс тийнхүү илүү нарийвчлан ангилах явдлыг үгүйсгэхгүй.

4 дүгээр зүйл

Хөгжиж буй улс хэсэгчлэн хэрэглэх нь

1. Хөгжиж буй улс болох Хэлэлцэн тохирогч аливаа Тал өөрийн олон улсын худалдааны төлөв байдал эсвэл байгууллагын нөөц бололцоог харгалзан үзэж Уялдуулсан системийн бүх эсвэл зарим мөрийг хэрэглэх явдлыг шаардлагатай гэж үзсэн хугацаагаар хойшлуулж болно.

2. Энэ зүйлийн дагуу Уялдуулсан системийг хэсэгчлэн хэрэглэхээр шийдвэрлэсэн хөгжиж буй улс болох Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Уялдуулсан системийн 6 оронтой кодыг тухайн Талын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дотор, эсвэл энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу шаардлагатай гэж үзсэн түүнээс хойших хугацаанд бүтнээр нь хэрэглэхийн төлөө өөрийн бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллахыг хүлээн зөвшөөрч байна.
3. Энэ зүйлийн дагуу Уялдуулсан системийг хэсэгчлэн хэрэглэхээр шийдвэрлэсэн хөгжиж буй улс болох Хэлэлцэн тохирогч аль нэг Тал аливаа нэг-зураас бүхий мөрийн хоёр-зураас бүхий бүх мөрийг эсвэл аливаа зүйлийн нэг-зураас бүхий бүх мөрийг бүтнээр нь хэрэглэнэ, эсвэл бүхэлд нь хэрэглэхгүй. Ийнхүү хэсэгчлэн хэрэглэх тохиолдолд Уялдуулсан системийн хэрэглэхгүй үлдээсэн кодын 6 дахь эсвэл 5 болон 6 дахь оронгийн тоог "0" буюу "00"-ээр тус тус орлуулж тэмдэглэнэ.
4. Энэ зүйлийн дагуу Уялдуулсан системийг хэсэгчлэн хэрэглэхээр шийдвэрлэсэн хөгжиж буй аль нэг улс Хэлэлцэн тохирогч Тал болох үедээ тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдөр хэрэглэхгүй байх мөрийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ, мөн түүнээс хойших хугацаанд хэрэглэх мөрийн талаар мөн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.
5. Энэ зүйлийн дагуу Уялдуулсан системийг хэсэгчлэн хэрэглэхээр шийдвэрлэсэн хөгжиж буй аливаа улс Хэлэлцэн тохирогч Тал болох үедээ Уялдуулсан системийн 6 оронтой кодыг бүтнээр нь тухайн орны хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жилийн дотор хэрэглэх үүргийг албан ёсоор хүлээж байгаа талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.
6. Энэхүү зүйлийн заалтын дагуу Уялдуулсан системийг хэсэгчлэн хэрэглэхээр шийдвэрлэсэн хөгжиж байгаа аливаа улс хэрэглэхгүй байгаа мөрийн хувьд 3 дугаар зүйлийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөнө.

5 дугаар зүйл

Хөгжиж буй улсад үзүүлэх техникийн туслалцаа

Хөгжингүй улс болох Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлт гаргасан хөгжиж буй улсад харилцан тохирсон нөхцлөөр, тухайлбал, боловсон хүчин бэлтгэх, тэдний жагсаалтыг Уялдуулсан систем рүү шилжүүлэх ажил, түүнчлэн тэдний системд Уялдуулсан системийн нэмэлт, өөрчлөлтийг тусгах эсвэл энэхүү конвенцийн заалтыг мөрдөх явцад зөвлөгөө өгөх асуудлаар техникийн туслалцаа үзүүлнэ.

6 дугаар зүйл

Уялдуулсан системийн хороо

1. Энэхүү конвенцийн үндсэн дээр Хэлэлцэн тохирогч Тал бүрийн төлөөлөгчдөөс бүрдсэн Уялдуулсан системийн хороо хэмээх Хороог байгуулна.
2. Хороо ердийн нөхцөлд жил тутам хоёроос доошгүй удаа хуралдана.
3. Хорооны хуралдааныг Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулах бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр шийдвэрлээгүй бол Зөвлөлийн төв байранд явуулна.

4. Уялдуулсан системийн хороонд Хэлэлцэн тохирогч Тал бүр нэг санал өгөх эрхтэй байна. Харин гаалийн эсвэл эдийн засгийн холбоо, түүний нэг буюу хэд хэдэн гишүүн улс энэхүү конвенцийн хэлэлцэн тохирогч Тал болсон тохиолдолд Хэлэлцэн тохирогч тэдгээр Тал энэхүү конвенцийн зорилгоор, мөн хойшид байгуулагдах аливаа конвенцид хохирол учруулалгүйгээр хамтдаа зөвхөн нэг л саналын эрхтэй байна. Үүний нэгэн адил 11 дүгээр зүйлийн (b) заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Тал болох эрхтэй гаалийн эсвэл эдийн засгийн холбооны бүх гишүүн улс энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болсон бол тэдгээр нь хамтдаа зөвхөн нэг л саналын эрхтэй байна.
5. Уялдуулсан системийн хороо нь хорооныхоо дарга болон нэг эсвэл хэд хэдэн орлогчийг өөрөө сонгоно.
6. Хороо нь өөрийн дэгийг гишүүдэд ногдох саналын гуравны хоёроос доошгүй хувийн шийдвэрээр гаргана. Ийнхүү гаргасан дэгийг Зөвлөл батална.
7. Хороо нь өөрийн ажилд ажиглагчаар оролцуулах нь зүйтэй гэж үзсэн Засгийн газар хоорондын эсвэл олон улсын бусад байгууллагыг урина.
8. Хороо нь, ялангуяа, 7 дугаар зүйлийн 1 (a) заалтыг харгалзан үзэж шаардлагатай бол салбар хороо эсвэл ажлын хэсэг байгуулах бөгөөд уг салбар хороо эсвэл ажлын хэсгийн гишүүнчлэл, саналын эрх болон дэгийг тодорхойлно.

7 дугаар зүйл

Хорооны гүйцэтгэх ажил үүрэг

1. Уялдуулсан системийн хороо нь 8 дугаар зүйлийн заалтыг харгалзан үзэж дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:
 - (a) ялангуяа, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага болон технологийн хөгжил буюу олон улсын худалдааны төлөв байдалд гарч буй өөрчлөлтийг харгалзан үзэж, энэхүү конвенцид оруулах шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг санал болгох;
 - (b) Тайлбар бичиг, ангиллын санал дүгнэлт эсвэл Уялдуулсан системийг тайлбарлахад чиглэл болгон ашиглах зориулалттай бусад заавар зөвлөмжийн төсөл боловсруулах;
 - (c) Уялдуулсан системийг нэг мөр тайлбарлах, хэрэглэх явдлыг хангахад чиглэсэн зөвлөмжийн төсөл бэлтгэх;
 - (d) Уялдуулсан системийг хэрэглэхтэй холбогдсон мэдээллийг эмхэтгэн цэгцэлж тараах;
 - (e) Хэлэлцэн тохирогч Талууд, Зөвлөлийн гишүүд, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн Засгийн газар хоорондын эсвэл олон улсын бусад байгууллагад өөрийн санаачилгаар, эсвэл тэдний хүсэлтээр Уялдуулсан системийн барааны ангилалтай холбогдсон аливаа асуудлаар мэдээлэл, чиглэл өгөх;

- (f) өөрийн үйл ажиллагааны талаар, түүний дотор санал болгож буй нэмэлт өөрчлөлт, тайлбар бичиг, ангиллын санал дүгнэлт болон бусад заавар зөвлөмжийн талаар Зөвлөлийн чуулган бүрт тайлагнах;
 - (g) Уялдуулсан системтэй холбогдуулан Зөвлөлөөс, эсвэл Хэлэлцэн тохирогч Талуудаас шаардлагатай гэж үзсэн бусад бүрэн эрх, ажил үүргийг хэрэгжүүлэх.
2. Уялдуулсан системийн хорооны захиргаа, аж ахуйн шинжтэй бөгөөд төсөв хөрөнгө шаардсан асуудлаар гаргах шийдвэрийг Зөвлөл батална.

8 дугаар зүйл

Зөвлөлийн гүйцэтгэх үүрэг

1. Зөвлөл энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулахаар Уялдуулсан системийн хорооноос бэлтгэсэн саналыг хянан үзэж, хэрэв энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох Зөвлөлийн аливаа нэг гишүүн тухайн саналыг эсвэл түүний аль нэг хэсгийг дахин нягтлан шалгуулахаар Уялдуулсан системийн Хороонд буцаах хүсэлт гаргаагүй бол 16 дугаар зүйлд заасны дагуу Хэлэлцэн тохирогч Талуудад хэрэгжүүлэхийг зөвлөнө.
2. Уялдуулсан системийн хорооны чуулганы явцад 7 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу бэлтгэсэн тайлбар бичиг, ангиллын санал дүгнэлт, Уялдуулсан системийг хэрхэн тайлбарлах тухай бусад заавар зөвлөгөө, түүнчлэн Уялдуулсан системийг нэг мөр тайлбарлах, хэрэглэх явдлыг хангахад чиглэсэн зөвлөмжийг хэрэв энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тухайн асуудлыг Зөвлөлөөр оруулах хүсэлтэй байгаа тухайгаа дээрх чуулган хаагдсан сарын дараах сар дуусахаас өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдээгүй бол Зөвлөл баталсан гэж үзнэ.
3. Хэрэв асуудлыг энэ зүйлийн 2 дахь заалтын дагуу Зөвлөлөөр оруулсан бол Зөвлөл холбогдох тайлбар бичиг, ангиллын санал дүгнэлт, бусад заавар зөвлөгөө, эсвэл зөвлөмжийг хэрэв энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох Зөвлөлийн аливаа нэг гишүүн тэдгээрийг бүхэлд нь, эсвэл зарим хэсгийг дахин нягтлан шалгуулахаар Уялдуулсан системийн Хороонд буцаах хүсэлт гаргаагүй бол батална.

9 дүгээр зүйл

Гаалийн татварын хувь хэмжээ

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү конвенцийн дагуу гаалийн татварын хувь хэмжээтэй холбогдуулан ямар нэг үүрэг хүлээгээгүй болно.

10 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

1. Энэхүү конвенцийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг болж өгвөл хоорондоо хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

2. Шийдвэрлэгдээгүй маргааныг уг маргаанд оролцогч Талууд Уялдуулсан системийн хороонд шилжүүлнэ. Хороо холбогдох маргааныг авч үзээд хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж гаргана.
3. Хэрэв Уялдуулсан системийн хороо уг маргааныг шийдвэрлэж чадахгүй бол холбогдох асуудлыг Зөвлөлд өргөн мэдүүлнэ. Зөвлөл нь Зөвлөл байгуулах тухай конвенцийн 3 дугаар зүйлийн (е) заалтын дагуу зөвлөмж гаргана.
4. Маргаанд оролцогч Талууд Хорооны эсвэл Зөвлөлийн зөвлөмжийг заавал дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрөх талаар урьдчилан тохиролцож болно.

11 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Тал болох боломжтой байдал

Дор дурдсан улс эсвэл холбоо энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох боломжтой:

(а) Зөвлөлийн гишүүн улс;

(d) энэхүү конвенцоор зохицуулсан зарим эсвэл бүх асуудлаар гэрээ байгуулах эрх олгогдсон гаалийн эсвэл эдийн засгийн холбоод; мөн

(е) Зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу Ерөнхий нарийн бичгийн даргаас гишүүнээр элсэх урилга илгээсэн аливаа бусад улс.

12 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал болох журам

1. Хэлэлцэн тохирогч Тал болох боломжтой аливаа улс, гаалийн эсвэл эдийн засгийн холбоо нь дараах байдлаар энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болж болно:
 - (а) конвенцийг соёрхон батлах тухай тайлбар хийлгүйгээр түүнд гарын үсэг зурснаар;
 - (b) конвенцийг соёрхон батлах тухай тайлбар хийж түүнд гарын үсэг зурсны дараа соёрхон баталсан баримт бичгээ хадгалуулснаар; эсвэл
 - (c) конвенцид гарын үсэг зурах нээлттэй хугацаа дууссаны дараа түүнд нэгдэн орсноор.
2. Энэхүү конвенцийн 11 дүгээр зүйлд дурдсан улс, гаалийн эсвэл эдийн засгийн холбоод 1986 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд Брюссель хотноо байрладаг Зөвлөлийн төв байранд гарын үсэг зурахад нээлттэй байна. Түүнээс хойш түүнд нэгдэн ороход нээлттэй болно.
3. Соёрхон баталсан эсвэл нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

13 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох нь

1. Энэхүү конвенцийн 11 дүгээр зүйлд дурдсан арван долоогоос доошгүй тооны улс, гаалийн эсвэл эдийн засгийн холбоо соёрхон батлах тухай тайлбар хийлгүйгээр түүнд гарын үсэг зурсан, эсвэл соёрхон баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш дор хаяж гурван сарын хугацаа өнгөрсний дараа эхний 01 дүгээр сарын 01-ний өдөр, гэхдээ 1988 оны 01 дүгээр сарын 01-нээс наашгүй хугацаанд хүчин төгөлдөр болно (*Энэ заалтыг 1986 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Брюссель хотноо байгуулсан “БТКУС-ийн тухай олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-оор өөрчлөн найруулсан*).
2. Энэхүү зүйлийн 1 дэх заалтад дурдсан тоо доод хязгаартаа хүрсний дараа соёрхон батлах тухай тайлбар хийлгүйгээр түүнд гарын үсэг зурсан, соёрхон баталсан, эсвэл нэгдэн орсон аливаа улс, гаалийн эсвэл эдийн засгийн холбооны хувьд энэхүү конвенц нь тэдгээр нь өөр эрт хугацаа заагаагүй бол соёрхон батлах тухай тайлбар хийлгүйгээр түүнд гарын үсэг зурсан, соёрхон баталсан, эсвэл нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулснаас хойш дор хаяж арван хоёр сар болсны дараа, гэвч хорин дөрвөн сараас хэтрэхгүй хугацаа өнгөрөх хооронд тохиолдох 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болно. Гэвч энэ заалтын хүчин төгөлдөр болох хугацаа энэ зүйлийн 1 дэх заалтад дурдсан хүчин төгөлдөр болох хугацаанаас наашгүй байна.

14 дүгээр зүйл

Хараат нутаг дэвсгэр энэхүү конвенцийг мөрдөх нь

1. Аливаа улс олон улсын харилцааг нь хариуцдаг бүх, эсвэл зарим нутаг дэвсгэрт нь энэхүү конвенц хамаарч байгаа гэдгийг өөрийн мэдэгдэлд нэр заан дурдаж, энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох үедээ, эсвэл түүнээс хойш аль ч хугацаанд Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар тунхаглаж болно. Уг мэдэгдэл нь хэрэв түүнд өөр эрт хугацаа заагаагүй бол түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш дор хаяж арван хоёр сар болсны дараа, гэвч хорин дөрвөн сараас хэтрэхгүй хугацаа өнгөрөх хооронд тохиолдох 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болно. Гэвч энэхүү конвенц нь холбогдох улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө тухайн нутаг дэвсгэрт хамаарахгүй.
2. Энэхүү конвенц нь дурдсан нутаг дэвсгэрийн хувьд холбогдох Хэлэлцэн тохирогч Тал олон улсын харилцааг нь хариуцахаа больсон өдөр эсвэл 15 дугаар зүйлд заасан журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн түүнээс өмнөх хугацаанд хүчингүй болно.

15 дугаар зүйл

Цуцлах нь

Энэхүү конвенцийг хязгааргүй хугацаагаар байгуулсан болно. Гэвч, Хэлэлцэн тохирогч аливаа Тал энэхүү конвенцийг цуцалж болох бөгөөд уг цуцлалт нь хэрэв өөр хойшилсон хугацаа заагаагүй бол тийнхүү цуцалсан тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

16 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт оруулах журам

1. Зөвлөл энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулахаар Хэлэлцэн тохирогч Талуудад санал тавьж болно.
2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тийнхүү санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн талаар эсрэг саналтай байгаа тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болох бөгөөд дараа нь энэ зүйлийн 3 дахь заалтад заасан хугацаанд уг эсрэг саналаа буцаан татаж болно.
3. Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлт нь түүний талаар Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдсэнээс хойш 6 сар болмогц, гэхдээ энэ хугацаанд ямар нэгэн эсрэг санал гараагүй тохиолдолд хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзнэ.
4. Батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь Хэлэлцэн тохирогч бүх Талын хувьд дараах өдрүүдийн аль нэгэнд нь хүчин төгөлдөр болно. Үүнд:
 - (a) хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар 04 дүгээр сарын 01-нээс өмнө мэдэгдсэн бол тухайн мэдэгдлийг үйлдсэн өдрийн дараах жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр; эсвэл
 - (b) хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар 04 дүгээр сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойш мэдэгдсэн бол тухайн мэдэгдлийг үйлдсэн өдрийн дараах гурав дахь жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр.
5. Хэлэлцэн тохирогч Талын статистикийн жагсаалт, мөн түүний гаалийн тарифын жагсаалт, эсвэл 3 дугаар зүйлийн 1 (с)-д дурдсан тохиолдолд түүний тариф/статистикийн нэгдсэн жагсаалт нь энэ зүйлийн 4 дэх заалтад заасан өдөр болоход нэмэлт, өөрчлөлт оруулсан Уялдуулсан системд нийцсэн байна.
6. Энэхүү конвенцид соёрхон батлах тухай тайлбар хийлгүйгээр гарын үсэг зурсан, түүнийг соёрхон баталсан, эсвэл түүнд нэгдэн орсон аливаа улс, гаалийн, эсвэл эдийн засгийн холбоо нь түүнийг Хэлэлцэн тохирогч Тал болох өдөр хүчин төгөлдөр болсон, эсвэл энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн аливаа нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

17 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудаас Уялдуулсан системтэй холбогдуулан эдлэх эрх

- 6 дугаар зүйлийн 4 дэх заалт, 8 дугаар зүйл, мөн 16 дугаар зүйлийн 2 дахь заалт нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талд Уялдуулсан системд холбогдох аливаа асуудлаар дараах эрхийг олгож байна. Үүнд:
- (a) Уялдуулсан системийн энэхүү конвенцийн заалтын дагуу хэрэглэж байгаа бүх хэсэгт холбогдох; эсвэл
 - (b) түүний хувьд энэхүү конвенц нь 13 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болох өдрийг хүртэл, Уялдуулсан системийн энэхүү Конвенцийн дагуу тухайн өдрөөс хэрэглэхээр үүрэг хүлээсэн бүх хэсэгт холбогдох; эсвэл

- (с) 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтад заасан гурван жилийн хугацаанд Уялдуулсан системийн нийт 6 оронтой кодыг хэрэглэх албан ёсны үүрэг хүлээсэн тохиолдолд, мөн энэ хугацааг дуустал, Уялдуулсан системийн бүх хэсэгт холбогдох.

18 дугаар зүйл

Тайлбар

Энэхүү конвенцид ямар нэгэн тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

19 дүгээр зүйл

Ерөнхий нарийн бичгийн даргаас хийх мэдэгдэл

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Хэлэлцэн тохирогч Тал гарын үсэг зурсан бусад улс, Зөвлөлийн гишүүн боловч энэхүү конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал бус улс, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад дараах зүйлийн талаар мэдэгдэнэ:

- (a) 4 дүгээр зүйлийн дагуу хүлээн авсан мэдэгдлийн тухай;
- (b) 12 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан эсвэл нэгдэн орсон тухай;
- (c) 13 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болох өдрийн тухай;
- (d) 14 дүгээр зүйлийн дагуу хийсэн мэдэгдлийн тухай;
- (e) 15 дугаар зүйлийн дагуу хийсэн цуцлалтын тухай;
- (f) 16 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцид оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн тухай;
- (g) 16 дугаар зүйлийн дагуу санал болгосон нэмэлт, өөрчлөлттэй холбогдсон эсрэг саналын тухай, мөн боломжтой бол уг эсрэг саналаасаа татгалзсан тухай; мөн
- (h) 16 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэмэлт, өөрчлөлт, түүний хүчин төгөлдөр болох хугацааны тухай.

20 дугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх

Энэхүү конвенц нь Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын өргөн мэдүүлснээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэгдэнэ.

Дээр дурдсаныг гэрчилж дор гарын үсэг зурагсад, зохих ёсоор өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Брюссель хотноо 1983 оны 06 дугаар сарын 14-ний өдөр англи, франц хэлээр нэг эх хувь үйлдэв. Хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байх бөгөөд эх хувийг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга хадгалж, түүний баталгаат хуулбарыг 11 дүгээр зүйлд заасан бүх улс, гаалийн эсвэл эдийн засгийн холбоодод хүргүүлнэ.

УЯЛДУУЛСАН СИСТЕМИЙН ЕРӨНХИЙ ТАЙЛБАР ДҮРЭМ

“Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн Жагсаалтын дагуу барааг ангилахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Хэсэг, бүлэг болон дэд бүлгийн гарчиг нь барааг ангилахад зөвхөн анхан шатны лавлагаа баримжаа болно. Хууль ёсны ангилал нь зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, бүлгийн тайлбараар тодорхойлогдохын зэрэгцээ эдгээр зүйл болон тайлбарт өөрөөр заагаагүй бол дор дурдах дүрмийн заалтыг баримтална.
2. (a) Аливаа зүйлд дурдагдах ямар нэг бараа бүтээгдэхүүнтэй холбоотой заалт нь тухайн бараа, бүтээгдэхүүний үндсэн онцлог шинжийг хадгалж буй иж бүрдэл болоогүй буюу гүйцэт боловсруулаагүй бүтээгдэхүүнд нэгэн адил хамаарна. Энэ заалт нь мөн иж бүрдэл болсон, гүйцэт боловсруулсан боловч (эсвэл энэхүү дүрмийн дагуу иж бүрдэл болсон, гүйцэт боловсруулсанд тооцогдох) эвлүүлж угсраагүй буюу салган задалсан бараа, бүтээгдэхүүнд нэгэн адил хамаарна.
(b) Аливаа зүйлд дурдагдах материал, бодистой холбоотой заалт нь тухайн материал, бодисыг өөр бусад материал, бодистой хольсон хольц, нэгдэлд нэгэн адил хамаарна. Тодорхой нэг материал буюу бодисоор хийгдсэн бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой заалт нь тухайн материал буюу бодисоор бүхэлдээ буюу хэсэгчлэн хийгдсэн бараа бүтээгдэхүүнд нэгэн адил хамаарна. Нэгээс дээш тооны материал буюу бодисоор хийгдсэн бараа, бүтээгдэхүүнийг 3-р дүрмийн зарчмыг баримтлан ангилна.
3. 2 (b) дүрмийг хэрэглэх үед буюу бусад шалтгаанаар тухайн бараа, бүтээгдэхүүн нь хоёр буюу түүнээс дээш зүйл ангиар ангилагдаж болох тохиолдолд дараах байдлаар ангилна. Үүнд:
 - (a) Тухайн барааны шинжийг ерөнхийд нь тодорхойлж заасан зүйл ангиас илүү нарийн тодорхойлж заасан зүйл ангийг эрхэмлэнэ. Гэхдээ, хоёр буюу түүнээс дээш зүйл тус бүр нь хольц буюу нийлмэл бүтэцтэй барааны агуулгад орсон материал буюу бодисын зөвхөн нэг хэсэг эсвэл жижиглэн худалдаалах зориулалтаар савлагдсан иж бүрдэл барааны зөвхөн нэг хэсгийг тодорхойлж байвал тэдгээрийн аль нэг нь арай дэлгэрэнгүй тодорхойлолт өгч байлаа ч гэсэн адил тэнцүү ач холбогдолтойд тооцно.
 - (b) Янз бүрийн материалаас тогтсон буюу янз бүрийн бүрдэл хэсгүүдээр хийгдсэн холимог, нийлмэл бүтэцтэй бараа болон 3 (a) дүрмээр ангилагдах боломжгүй, жижиглэн худалдаалах зориулалтаар иж бүрдэл болгон савласан барааны хувьд тэдгээрийн үндсэн шинжийг тодорхойлогч нэг материал буюу бүрдэл хэсгээр хийсэнд тооцож ангилна. Гэхдээ энэ шалгуурыг ашиглаж болох тохиолдолд л энэ заалтыг мөрдөнө.
 - (c) Хэрэв ийм бараа бүтээгдэхүүнийг дээрх 3 (a) буюу 3 (b) дүрмийн дагуу ангилах боломжгүй бол адил тэнцүү ач холбогдолтойд тооцогдох зүйлүүдээс Жагсаалтад дэс дугаараараа сүүлийнх нь болох зүйл ангид хамааруулж ангилна.
4. Өмнө дурдсан дүрмүүдийг хэрэглэн ангилах боломжгүй бараа бүтээгдэхүүнийг тэдгээртэй хамгийн ойр төстэй бараа бүтээгдэхүүний зүйл ангид хамааруулж ангилна.
5. Өмнө дурдсан дүрмүүдэд нэмэлт болгон, тэнд дурдагдсан барааны тухайд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - (a) Ямар нэгэн бараа, иж бүрдэл барааг хадгалж, агуулж байх зорилгоор тохирсон хэв загвар гарган үйлдсэн, яс чанар сайтай, удаан эдэлгээтэй, тухайн бараатайгаа хамт нийлүүлдэг, зургийн аппаратын гэр, хөгжмийн зэмсэг, бууны гэр, зургийн хэрэгсэл, зүүлт, чимэглэлийн хайрцаг гэх мэт гэр, хайрцаг, савыг хамтад нь худалдан

борлуулах бараа бүтээгдэхүүнийх нь харгалзах зүйл ангид хамааруулан ангилна. Гэвч энэ дүрмийг өөрийнхөө онцлог шинж төлвийг бүхэлдээ хадгалсан, бие даасан шинжтэй гэр, хайрцаг, савыг ангилахад хэрэглэхгүй.

- (b) Дээрх 5 (a) дүрэмд заасны адилаар бараа, бүтээгдэхүүнийг савласан аливаа авдар, сав, хайрцаг нь тухайн бараа, бүтээгдэхүүнийг савлахад хэрэглэдэг түгээмэл, ердийн сав, баглаа боодол байх тохиолдолд уг бараа бүтээгдэхүүнээ дагаж хамт ангилагдана. Харин, сав, авдар, чингэлэг, хайрцаг нь дахин ашиглагдахаар байвал дээрх заалтыг ямагт мөрдөх албагүй.
6. Аливаа нэгэн зүйлийн доторх бараа бүтээгдэхүүнийг мөрүүдэд хуваан, хүчин төгөлдөр ангилалт хийхийн тулд тухайн мөрүүдийн нэршил, томъёолол болон харгалзах мөрийн тайлбаруудыг үндэслэл болгон зөвхөн ижил түвшингийн мөрүүдийг өөр хооронд нь харьцуулж, өмнөх дүрмүүдийн заалтыг тохируулан хэрэглэж ангилна. Энэ дүрмийг хэрэглэх явцад, утга нь өөрөөр заагаагүй бол холбогдох Хэсэг ба Бүлгийн тайлбарыг нэгэн адил мөрдөнө.